

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН
ТАЙЛАН

/2018 оны жилийн эцсийн байдлаар/

2018.12.28

Газрын хэмжээнд 2018 оны бүтэн жилийн байдлаар иргэд, аж ахуйн нэгжүүдээс нийт 2 өргөдөл ирсэн. Хэрхэн шийдсэн тухайд:

ӨРГӨДӨЛ 1.

Хэнээс: А.Амгаланзаяа

Ирсэн огноо: 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр

Шийдвэрлэсэн огноо: 2018 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр

Өргөдлийн гол утга: Иргэн А.Амгаланзаяагаас арьс ширний үйлдвэрийн хотоос нүүлгэх тухай.

Зохион байгуулалтын явц: ХУД-ийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт арьс ширний үйлдвэр их байгаатай холбоотойгоор хөрсний бохирдол нэн аюултай түвшинд байна. Агаарт хортой бодис ихээр ялгарч, бараг жилийн дөрвөн улиралд өмхий үнэр ихээр үнэртэж, гадаа хүүхэдтэйгээ салхилах боломжгүй байна. Иймд агаар болон хөрсний бохирдлын асуудлыг шийдэж өгнө үү. Хортойг нь мэдэж байж анхнаасаа тэнд байр барихыг зөвшөөрсөн, шуналд автсан улсын байгууллагын нөхдүүд зүгээр өнгөрөхгүй байх гэж найдаж байна. Иймээс эдгээр үйлдвэрүүдийг хотоос нүүлгэж өгнө үү. Иргэн А.Амгаланзаяатай Үйлдвэрлэлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Төмөрбаатар утсаар холбогдож Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн паркийн талаарх мэдээллийг хүргэсэн.

ХЯНАСАН
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ГАНЦЭЦЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Ж.ТАМЖИД